

**Петро Матад Лимитед (“Петро Матад” эсвэл “Компани” гэх)
XX талбайн өрөмдлөгийн талаархи шинэчилсэн мэдээлэл**

ДТ-4 цооногийн өрөмдлөгийг эхлүүлсэн тухай

Петро Матад (AIM-MATD) нь Монгол Улсын орон нутгийн цагаар 2010 оны 11 дүгээр сарын 15-ны шөнийн 00:00 цагт (Гринвичийн стандарт цагаар 2010 оны 11 дүгээр сарын 15-ны 16:00 цагт) Давсан Толгой-4 цооногийн (цаашид “ДТ-4” гэх) өрөмдлөгийг эхлүүлсэнийг мэдэгдэхэд таатай байна.

ДТ-4 цооногийг 2,020 метрийн гүнд хүртэл босоо чиглэлээр өрөмдөж байна. Цооногийн өрөмдлөгийг манай туслан гүйцэтгэгч Ди Кью И Интернешнл компани (DQE International) гүйцэтгэж байна. Өрөмдлөг дууссаны дараа эсвэл ажлын явцтай уялдуулан дараагийн мэдээллийг хүргэх болно. Энэхүү цооногийн өрөмдлөгөөр Баруун Давсан Толгой хэмээх хагарлын блокын нэг хэсэг болох дөрвөн талаасаа хаагдсан гүдэн бүтцийг судлах юм. ДТ-4 цооног нь ДТ-1 цооногийн талбайгаас баруун зүгт 3.4 километрийн зайд байрлана.

Мэдээллийг хянан тохиолдуулагч нарын анхааралд:

Петро Матад Лимитед компанийн тухай

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай Бүтээгдэхүүн Хуваах гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол орны зүүн хэсэгт орших 10,340 хавтгай дөрвөлжин километр талбай бүхий газрын тосны XX талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (“БХГ” гэх) юм. Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайд нь Монгол орны төв хэсэгт оршдог бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 хавтгай дөрвөлжин километр талбайг хамарна.

Петро Матад Лимитед нь 1483V компанийн бүртгэлийн дугаартайгаар Айл эф Мэн (Isle of Man) аралд үүсэн байгуулагдсан. Албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспет Хилл, Дуглас, Айл эф Мэн, Ай Эм 1, ИИКью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг.

Нэмэлт мэдээллийг:

Петро Матад Лимитэд

Ерөнхий Гүйцэтгэх Захирал - Даглас Жэй МакГэй (Douglas J. McGay)

+976 11 331099

Уэстхауз Секьюритиз Лимитэд

Ричард Бэти/Питр Нортон (Richard Baty/Petre Norton)

+44 (0)20 7601 6100